



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 32

Даланзадгад сум

“Чинээлэг малчин” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцон жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б. БАДРАА

462210142



"ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН" ХӨТӨЛБӨР /2020-2024 ОН/

Нэг. Нийтлэг үндэслэл, шаардлага

Өмнөговь аймгийн эдийн засгийн хөгжилд мал аж ахуйн салбар одоог хүртэл тэргүүлэх байр суурийг эзэлдэг. 2020 оны жилийн эцсийн байдлаар аймаг 2.8 сая толгой малтай, 6546 малчин өрх, 10219 малчин байгаа нь нийт өрхийн 29.7%, хүн амын 14.2%-ийг тус тус эзэлдэг, орон нутгийн махны хэрэглээний 95%, сүү сүүн бүтээгдэхүүний 50%-ийг хангадаг хамгийн том салбар төдийгүй нөхөн сэргээгддэг баялаг салбар юм.

Мал сүргийг төрлөөр нь авч үзвэл тэмээ 166800, адуу 110395, үхэр 33192, хонь 682598, ямаа 1887787, нийт 2880772 толгой мал тоолуулсан ч хоорондын харьцаа зохистой биш, нийт сүрэгт тэмээ 5.7%, адуу 3.8%, үхэр 1.1%, хонь 23.6%, ямаа 65.5%-ийг тус тус эзэлж байна. Мөн сүргийн зохистой бүтэц алдагдан сүрэгт хээлтэгчийн эзлэх хувь багасч эр сувай малын эзлэх хувийн жин нэмэгдсэн. Сүүлийн жилүүдийн дунджаар аймгийн хэмжээнд 200000 толгой малыг өрхийн хүнсний хэрэгцээнд хэрэглэж, нийт малын 10 хүрэхгүй хувь буюу дунджаар 230000 толгой малыг зах зээлд борлуулж байгаа нь мал сүрэг эдийн засгийн эргэлтэд хангалттай орохгүй байгааг харуулж байна.

Аймгийн хэмжээнд Говь Гурван Сайхан ямаа, Галбын Говийн Улаан тэмээ, Ханын Хэцийн Хүрэн тэмээ гэсэн баталгаажсан үүлдрийн малын үндсэн цөм сүргүүд үржүүлэгддэг. 2020 оны байдлаар Галбын Говийн Улаан тэмээ 14484, Ханын Хэцийн Хүрэн тэмээ 13008, Говь Гурван Сайхан ямаа 86069 -аар тус тус тоологдсон.

Уул уурхайн болон сумдын төвийг түшиглэсэн туслах аж ахуй, цөөн тооны үхэртэй сүүний эрчимжсэн аж ахуйн эрхлэх боломж байгаа ч тэжээлийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна. Мал хувийн өмчид шилжсэнээс хойш малчид өөрсдийн зоргоор хээлтүүлэгчийг сонгон хяналтгүй тавьснаар малын үүлдэрлэг байдал алдагдан нэг малаас авах ашиг шим багасах, малын тэсвэрт чанар муудах, хэнз давжаа төл гарах, намрын үзлэг, заазлалтыг стандартын дагуу хийж хэрэгцээний сүргийг зах зээлд бүрэн нийлүүлэхгүй байгаагаас малын зүй бус хорогдол нэмэгдэх үндсэн шалтгаан болсон.

Мөн малын гаралтай түүхий эд бэлтгэл, нийлүүлэлтийн нэгдсэн систем, зохион байгуулалтгүй болсноор малын гаралтай түүхий эд үнэгүйдэх, хаягдах, малчдын орлого багасах, дан ганц ямааг ноолуурт шүтэн өсгөх зэрэг сөрөг үр дүн гарсан ба уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж харьцангуй бага, байгалийн бэрхшээлд амархан өртдөг, хөдөлмөр нь гар аргаар хийгддэг тул хүнд, цаг хугацаа их шаарддаг зэрэг нь малчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ үйлдвэрлэлийг түүхий эдээр тасралтгүй хангаж чадахгүй хүрсэн.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн суурь бааз болсон бэлчээрийн талбай багасаж, төлөв байдал сүүлийн жилүүдэд алдагдан талхлагдах, бэлчээрийн ургамлын төрөл зүйл цөөрөх, булаг, шанд, худгийн ус ширгэснээс усгүйдэх нь нэмэгдэж байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт, уур уурхайн хөгжил, суурин амьдралын хэв маяг, даацаас хэтэрсэн малын хэт өсөлттэй холбоотой юм. Аймгийн нийт бэлчээрийн 54,7% усжуулагдсан ч 5000 бэлчээрийн худгаас ус ууж байгаа нь нийт малын тоог хонин толгойд шилжүүлснээр нэг худгаас ус уух малын тоо стандартаас 2-3 дахин

хэтэрсэн. Отор нүүдлийн үед нэг худгаас 5000-10000 мал уухаар бөөгнөрч, худаг ус хүрэлцэхгүй, ус худаг шавхах асуудал үүсч байна. Байгалийн хадлан бэлтгэх боломжтой хадлангийн талбай байдаггүй ба зарим гол, хоолой даган гарсан зэрлэг сахилдаг, хулс, дэрсийг хадах, хөмөл, таанан зоодой хийх зэргээр багахан хэмжээний байгалийн хадлан бэлтгэдэг. Ихэнх нутгаар хужир, шүү хангалттай байдаг тул мал шорвоогоор дутагддаггүй байна.

Дэлхийн цаг агаарын дулаарал, байгаль цаг уурын өөрчлөлт, байгалийн давагдашгүй хүчин зүйл, ган зудын давтамж, хотжилт, төв суурингийн хүн амыг хэрэгцээ, уул уурхайн хөгжил, нийгмийн эрэлт хэрэгцээнд тохируулан мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх, тогтвортой хадгалах замаар үйлдвэрийг чанартай түүхий эдээр, хүн амыг аюулгүй хүнсээр хангах шаардлага гарч байна.

Төр засгаас малчид, мал аж ахуйн салбарт баримталж байгаа бодлого, хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан үр дүнтэй хэрэгжүүлэх, дээрх тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, цагийн хүндийг хохирол багатай даван туулах чанартай мал сүрэгтэй, эдийн засгийн боломжтой малчин өрхтэй, малын гаралтай түүхий эдээ орон нутагтаа боловсруулах боломжийг бүрдүүлсэн аймаг болохын төлөө энэхүү "Чинээлэг малчин" хөтөлбөрийг яаралтай хэрэгжүүлэх шаардлага байна.

Хууль эрх зүйн хувьд "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого", "Монгол мал" хөтөлбөр, "Ноолуур" хөтөлбөр, "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" гэх мэт олон хөтөлбөр, бодлогын баримт бичгүүд батлагдан хэрэгжиж байгаа ба эдгээр хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдийн хүрээнд орон нутгийн онцлогт тохирсон, илүү үр дүн өгөх, дэд хөтөлбөрийг шинэчлэн батлуулах зайлшгүй нийгмийн захиалга бүрдсэн байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, чиглэл, баримтлах зарчим

Энэхүү хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх зорилго нь "Монгол улсын үндсэн хууль", "Малын генетик нөөцийн тухай хууль", Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, бусад хууль, "Монгол мал", "Малын эрүүл мэнд", "Монгол малчин хөтөлбөрүүд "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого", "Эрчимжсэн аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр" зэрэг баримт бичгүүдийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах, орон нутгийн онцлогт тохируулан мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх замаар хүн амыг аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр тогтмол хангахад оршино.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

- Хүний эрх, эрх чөлөө, ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, хуулийг дээдлэх
- Малчин өрхийн эдийн засгийн чадавхи, бололцоо, хүсэл сонирхолд нь нийцсэн дэмжлэг үзүүлэх
- Уламжлалт мал аж ахуйн ололт, туршлага, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, эзэмшүүлэх, нутагшуулах
- Малчин хүний ашиг сонирхолыг илэрхийлэх, хамгаалах, туслан хөгжүүлэх үйл ажиллагааг аль болох анхан шатны нэгжид, баг, хоршооны түвшинд дэмжих
- Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёл, түүх, арга барилаа уламжлан хөгжүүлэх, хадгалах, өвлүүлэх

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ.

- 3.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эдийн засгийн эргэлтэд оруулж чинээлэг малчин өрхийг бий болгох
- 3.2. Удам залгасан, залуу малчдыг дэмжин урамшуулж малчдын нийгмийн баталгааг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүн хүч, үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээ нэгтгэх, хорших зохион байгуулалтын хэлбэрт шилжүүлэх, зах зээлтэй холбох
- 3.3. Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах, цөм сүргийг тодорхойлох, бэхжүүлэх замаар түүхий эдийн чанарыг сайжруулж малчдын орлогыг нэмэгдүүлэх, зах зээлийг чанартай түүхий эдээр хангах
- 3.4. Мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, хүртээмж, мал аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулж, мал сүргийг ялган тэмдэглэх тогтолцоог хөгжүүлэх
- 3.5. Эрчимжсэн аж ахуйг орон нутгийн онцлогт тохируулан хөгжүүлэх

Дөрөв. Санхүүжилт

- 4.1. Улсын төсөв
- 4.2. Орон нутгийн төсөв
- 4.3. Малын тоо толгойн албан татвар
- 4.4. Төсөл хөтөлбөр
- 4.5. Зээл, тусламж
- 4.6. Хандив
- 4.7. Малчид, аж ахуй нэгжийн санаачлага
- 4.8. Бусад

Тав. Хугацаа, үе шат

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат 2020-2024 он

Зургаа. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Нэгдүгээр зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ: Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эдийн засгийн эргэлтэд оруулж чинээлэг малчин өрхийг бий болгох

1. Түргэн өсөлттэй хонины аж ахуйг хөгжүүлэх, үр дүнг сурталчлах, өндөр ашиг шимтэй хээлтэгч, хээлтүүлэгч нийлүүлэх замаар жишиг суурь, аж ахуй нэгж байгуулах, бусад төрлийн малыг шилмэл хээлтүүлэгчээр сайжруулан цөм сүргийн малыг нэмэгдүүлэх
2. Орон нутгийн малжуулах төслийг шинэчлэн хэрэгжүүлэх
3. Мал нядалгааны шугам, малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулах цехүүдийг түүхий эдийн нөөц, дэд бүтцийг түшиглүүлэн үе шаттайгаар бүсчлэн байгуулах, кластер-ложистикийн сүлжээ бий болгох ажлыг үр дүнтэй эхлүүлж малчдын орлогыг нэмэгдүүлэх
4. Малчдыг зах зээлтэй холбох, сурталчлах, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагддаг уламжлалт болон нэмэлт арга хэмжээнүүдийг зохион байгуулах
5. Хээлтүүлэгч малыг мэргэжиллийн үйлчилгээний нэгжид төвлөрүүлж, гарал үүсэл, ашиг шим нь тодорхой, эрүүл, баталгаажсан хээлтүүлэгчийг үржилд ашиглах

Хоёрдугаар зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ: Удам залгасан, залуу малчдыг дэмжин урамшуулж, малчдын нийгмийн баталгааг

сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүн хүч, үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээ нэгтгэх, хорших зохион байгуулалтын хэлбэрт шилжүүлэх, зах зээлтэй холбох

1. Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах, малчдын залуу халааг бэлтгэх, удам залгасан малчин өрхийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх
2. Малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоог хөгжүүлэх, дэмжих, зах зээлтэй холбох, зорилтот зах зээлд чиглэсэн төрөлжсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулах боломжийг нэмэгдүүлэх.
3. Мал аж ахуйн уламжлалт ёс заншлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, аялал жуулчлалын нэрийн бүтээгдэхүүн болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх
4. Мал аж ахуйн үйлдвэрлэлд малчдын хүнд гар хөдөлмөрийг механикжуулах, хөнгөвчлөх

Гуравдугаар зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ:

/Малын чанар үүлдэр угсааг сайжруулах, цөм сүргийг тодорхойлох, бэхжүүлэх замаар түүхий эдийн чанарыг сайжруулж малчдын орлогыг нэмэгдүүлэх, зах зээлийг чанартай түүхий эдээр хангах/

1. Тоо, толгой нь цөөрч буй үүлдэр, омог хэвшлийн мал сүргийг хамгаалах, тэмээ өсгөх бодлого хэрэгжүүлэх, тэмээний төрөлжсөн эмнэлэг байгуулах, ботгоны урамшуулал олгох
2. Аймгийн мал сүргийн ашиг шим суурь судалгааг малын төрөл тус бүр дээр давтамжтай явуулах ажлыг мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтран хэрэгжүүлж орон нутгийн шилмэл сүргийг илрүүлэх, судлах, хамгаалах
3. Батлагдсан үүлдэр омгийн малын цөм сүргийг өсгөж байгаа малчидтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, цөм сүргийн малаас өсвөр хээлтүүлэгч бойжуулах
4. Мал үржүүлэг, технологийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ:

/Мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, хүртэмжийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулж, мал сүргийг ялган тэмдэглэх тогтолцоог хөгжүүлэх/

1. Малын халдварт, зооноз, халдваргүй, шимэгчтэх өвчний үзлэг, урьдчилан сэргийлэх, тэмцэх, шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэн нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн хүн, мал эмнэлгийн салбар дундын хамтын ажиллагааг өргөтгөх
2. Мал сүргийн ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэн, цахим бүтгэлээр дамжуулан хяналтын тогтолцоог бэхжүүлэх, жил бүр холбогдох мэдээллийг баяжуулж хэвших
3. Монгол улсын малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн өндөр идэвхтэй, чанартай эм бэлдмэлээр ханган малын эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлсэн байх
4. Орон нутгийн мал аж ахуйн мэргэжилтнүүдийг чадавхижуулж боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх

Тавдугаар зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ:

/Эрчимжсэн аж ахуйг орон нутгийн онцлогт тохируулан хөгжүүлэх/

1. Бүтээмж өндөртэй мал сүрэг болон, өндөр ашиг шимт нэг төрлийн амьтан дагнан үржүүлж буй, эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлж буй иргэн аж ахуй нэгжийн үйл ажиллагааг зах зээлтэй холбох төсөл хөтөлбөрт хамруулан дэмжих

2. Хүн ам олноор суурьшсан сумдын мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний хэрэглээний зохих хувийг эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх замаар шийдвэрлэх
3. Тэжээлийн ургамалын тариалалтыг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх
4. Шинжлэх ухаан, биотехнологийн дэмшилтэд аргыг нэвтрүүлэх, цар хүрээг өргөжүүлэн хөгжүүлэх

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

- 7.1. Хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг сумдын Засаг даргын тамгын газар, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар хамтран гүйцэтгэнэ.
- 7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

- 8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга хөдөө аж ахуйн салбарын байгууллагууд хамтран гүйцэтгэж үр дүн, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.
- 8.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн эхний улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулна.
- 8.2. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮСНЭГТ

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эдийн засгийн эргэлтэд оруулж чинээлэг малчин өрхийг бий болгох						
1	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эдийн засгийн эргэлтэд оруулж чинээлэг малчин өрхийг бий болгох	Түргэн өсөлттэй хонин сүрэг бий болгох, үр дүнг сурталчлах, өндөр ашиг шимтэй хээлтүүлэгч нийлүүлэх замаар жишиг суурь, аж ахуй нэгж байгуулах, бусад төрлийн малд шаардлага гарвал шилмэл хээлтүүлэгч авах	Түргэн өсөлттэй хонь өсгөх малчид, аж ахуйн тоо, уул уурхайд нийлүүлэх малын тоо	Түргэн өсөлттэй хонины жишиг аж ахуйг бүсчлэн байгуулж малчдад сурталчилах, уул уурхай болон бусад зорилтот зах зээлд нийлүүлэх боломж бүрдүүлнэ	ОНТ, Төсөл, хөтөлбөр	ХХААГ, СЗДТГ, Мэргэжлийн үйлчилгээний нэгжүүд, малчид
		Орон нутгийн малжуулах төслийг шинэчлэн хэрэгжүүлэх	Малжуулах төсөлд хамрагдаж өрхийн орлогоо нэмэгдүүлсэн малчин өрхийн тоо	Малжуулах төсөлд Аймгийн хэмжээнд 100-аас доошгүй малчин өрхийг малжуулах төсөлд хамруулж орлогыг нь нэмэгдүүлсэн байна.	ОНТ	ХХААГ, Сумын ИТХ, СЗДТГ
		Мал нядалгааны шугам, малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулах цехүүдийг түүхий эдийн нөөц, Дэд бүтцийг түшиглүүлэн үе шаттайгаар бүсчлэн байгуулах, кластер-	Шинээр байгуулагдсан мал нядалгааны шугам, малын гаралтай түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх цехийн тоо	Бүсчилсэн байдлаар цехүүдийг байгуулж малын гаралтай түүхий эдийн 25%-д нэмүү өртөг шингээнэ.	ОНТ, Төсөл хөтөлбөр, малчид, аж ахуй нэгжүүд	АЗДТГ, ХХААГ, СЗДТГ

	<p>логистикийн сүлжээ бий болгох ажлыг үр дүнтэй эхлүүлж малчдын орлогыг нэмэгдүүлэх</p> <p>Малчдыг зах зээлтэй холбох, сурталчлах, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагддаг уламжлалт болон нэмэлт арга хэмжээнүүдийг зохион байгуулах</p>	<p>Уламжлалт болон нэмэлт арга хэмжээний чанар, хамрагдах иргэн, аж ахуй нэгжийн тоо, бараа бүтээгдэхүүний чанар дээшлүүлсэн байх</p>	<p>Уламжлалт болон нэмэлт эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах арга ажиллагааг боловсронгуй болж хамрах хүрээ нэмэгдсэн байна.</p>	<p>Улсын төсөв, ОНТ, төсөл хөтөлбөр</p>	<p>АИТХ, АЗДТГ, ХХААГ, СЗДТГ</p>
<p>Хээлтүүлэгч малыг мэргэжилтний мэдэлд төвлөрүүлэх, гарал үүсэл нь тодорхой, эрүүл, баталгаажсан хээлтүүлэгчийг үржилд ашиглах</p>	<p>Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ангид ялган суурилсан сумын тоо, хээлтүүлэгчийг ялгасан хувь</p>	<p>Гарал үүсэл нь тодорхой, баталгаажсан үүлдрийн хээлтүүлэгчийг үржилд ашигладаг болсон байна. Ингэснээр бог малын чанар сайжрах, хээлтүүлэгчээр дамжих малын өвчлөл багасна.</p>	<p>ОНТ, Аж ахуй нэгж, малчид</p>	<p>АЗДТГ, ХХААГ, СЗДТГ</p>	
<p>Зорилт 2: Удам залгасан, залуу малчдыг дэмжин урамшуулж, малчдын нийгмийн баталгааг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүн хүч, үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээ нээгтгэх, хорших зохион байгуулалтын хэлбэрт шилжүүлэх, зах зээлтэй холбох</p>					
<p>Удам залгасан, залуу малчдыг дэмжин урамшуулж, малчдын нийгмийн баталгааг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүн хүч, үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээ</p>	<p>Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах, малчдын залуу халааг бэлтгэх, удам залгасан малчин өрхийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх</p> <p>Малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоог хөгжүүлэх, дэмжих, зах зээлтэй холбох, зорилтот зах зээлд чиглэсэн төрөлжсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулах боломжийг нэмэгдүүлэх.</p>	<p>Малчдад зориулсан урт болон богино хугацааны сургалтын программ бий болгож уламжлалт мал аж ахуйг орчин үеийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх</p> <p>Дэмжлэг авсан удам залгасан малчдын тоо, мэргэжилтний хангамж</p>	<p>Зах зээлийн эдийн засагт бүрэн бэлтгэгдсэн шинжлэх ухааны эндэслэлтэй мал аж ахуйг хөгжүүлэх малчдыг бий болгосон байна.</p> <p>Удам залгасан шинэ малчин өрхүүдийг 100% дэмжлэгт хамруулсан байна. Мал аж ахуйн мэргэжилтнийг шат дараагаар бэлтгэсэн байна.</p>	<p>ОНТ, Төсөл, хөтөлбөр</p>	<p>ХХААГ, СЗДТГ, ахмад мэргэжилтнүүд</p>
<p>2</p>					

нэгтгэх, хорших зохион байгуулалтын хэлбэрт шилжүүлэх, зах зээлтэй холбох	Мал аж ахуйн уламжлалт ёс заншлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, аялал жуулчлалын нэрийн бүтээгдэхүүн болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт мэдлэгийг сурталчлах зорилгоор хийсэн сургалт, хамрагдсан хүнийй тоо, аялал жуулчлалын эвент болгон таниулсан байдал.	Мал аж ахуйн уламжлалт мэдлэгийг залуу үед өвлүүлэх, залуу малчдыг чадваржуулах, малчдын орлого нэмэгдэх	ООНТ АЗДТГ, ХХААГ, СЗДТГ
Мал аж ахуйн үйлдвэрлэлд малчдын хүнд гар хөдөлмөрийг механижуулах, хөнгөвчлөх	Мал аж ахуйн үйлдвэрлэлд малчдын хүнд гар хөдөлмөрийг механижуулах, хөнгөвчлөх	Орон нутгийн түүхий эдийн онцлогт тохирсон анхан шатны боловсруулах үйлдвэр цехийн тоо	Мал аж ахуйн гаралтай түүхий эдэд нэмүү өртөг шингэж, орон нутгийн онцлог, үйлдвэрийн онцлогт тохирсон нэг стандартын түүхий эд бэлтгэгдэнэ.	Улсын төсөв, ООНТ, төсөл хөтөлбөр АИТХ, АЗДТГ, ХХААГ, СЗДТГ

Зорилт 3: Малын чанар үүлдэр угсааг сайжруулах, цөм сүргийг тодорхойлох, бэхжүүлэх замаар түүхий эдийн чанарыг сайжруулж малчдын орлогыг нэмэгдүүлэх, зах зээлийг чанартай түүхий эдээр хангах

Малын чанар үүлдэр угсааг сайжруулах, цөм сүргийг тодорхойлох, цөм бэхжүүлэх замаар түүхий эдийн чанарыг сайжруулж малчдын орлогыг нэмэгдүүлэх, зах зээлийг чанартай түүхий эдээр хангах	Тоо, толгой нь цөөрц буй үүлдэр, омог хэвшлийн мал сүргийг хамгаалах, тэмээ өсгөх бодлого хэрэгжүүлэх, тэмээний төрөлжсөн эмнэлэг байгуулах, ботгоны урамшуулал олгох	Сайханы сарлаг арга хэмжээг өргөжүүлэх, тэмээний төрөлжсөн эмнэлэг байгуулах, ботгоны урамшууллыг үргэлжүүлэн олгох, нэмэгдүүлэх, тоо толгой нь цөөрсөн мал сүргийг өсгөж байгаа иргэн аж ахуй нэгжийг дэмжин ажиллах	Тоо толгой нь цөөрсөн мал сүргийг маллаж байгаа малчид, аж ахуй нэгжийг дэмжих системтэй болсон байна. Тэмээний төрөлжсөн эмнэлэгтэй болсон байна.	ООНТ, төсөл хөтөлбөр АИТХ, АЗДТГ, ХХААГ, МЭГ, СЗДТГ
Малын төрөл бүрээр ажшиг шимийн суурь судалгааг гаргаж цаашид баримтлах үржлийн төлөвлөгөөг гаргаж малын ашиг шимийг нэмэгдүүлэх, зах зээлд таниулах	Аймгийн мал сүргийн ашиг шим суурь судалгааг малын төрөл тус бүр дээр давтамжтай явуулах ажлыг мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтран хэрэгжүүлж орон нутгийн шилмэл сүргийг илрүүлэх, судлах, хамгаалах	Суурь судалгаа хийсэн малын төрөл, бүтээгдэхүүний төрөл, тоо	Малын төрөл бүрээр ажшиг шимийн суурь судалгааг гаргаж цаашид баримтлах үржлийн төлөвлөгөөг гаргаж малын ашиг шимийг нэмэгдүүлэх, зах зээлд таниулах	Улсын төсөв, ООНТ, Төсөл хөтөлбөр АЗДТГ, ХХААГ, мэргэжлийн холбоод

	Батлагдсан үүлдэр омгийн малын цөм сүргийг өсгөж байгаа малчидтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, цөм сүргийн малаас өсвөр хээлтүүлэгч бойжуулах	Батлагдсан үүлдэр, омгийн мал сүрэгт ангилалтын ажлыг тогтмол явуулж ашиг шим нь баталгаажсан мал сүргийг өсгөх, шинээр бойжуулсан хээлтүүлэгчийн тоо	Ашиг шимийн үзүүлэлт сайн, сүргийн зохистой бүтэц бүхий цөм сүргүүд бий болж нийт малын 20-оос доошгүй хувь нь цөм сүргийн мал болсон байна.	ОНТ, төсөл хөтөлбөр, Аж ахуй нэгж, малчид	ХХААГ, СЗДТГ, мэргэжлийн үйлчилгээний нэгж, Мэргэжлийн холбоод, ахмад мэргэжилтнүүд
	Мал үржүүлэг, технологийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах	Малын генетик нөөцийн тухай хуулийн дагуу мал үржүүлэг технологийн үйлчилгээний нэгжийг сум бүрд 1-ээс доошгүйг байгуулсан байна.	Мал аж ахуйн үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэн, үржлийн ажил үйлчилгээг мэргэжлийн түвшинд зохион байгуулан малын чанар үүлдэр угсааг сайжруулна	ОНТ, төсөл хөтөлбөр, Аж ахуй нэгж, малчид	АЗДТГ, ХХААГ, СЗДТГ
Зорилт 4: Мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, хүртэмжийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулж, мал сүргийг ялган тэмдэглэх тогтолцоог хөгжүүлэх					
4	Мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, хүртэмжийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулж,	Малын халдварт, зооноз, халдваргүй, шимэгчтэх өвчний үзлэг, урьдчилан сэргийлэх, тэмцэх, шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэн нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн хүн, мал эмнэлгийн салбар дундын хамтын ажиллагааг өргөтгөх	Тухайн жилийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээг 95-аас дээш хувиар ханган биелүүлж, халдварт өвчний гаралтыг 5 %-аас дээш бууруулсан байна	Халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээнд хамруулах малын тоо, зарцуулах зардлын хэмжээг жил бүрийн малын өсөлттэй уялдуулан нэмэгдүүлснээр халдварт, шимэгчтэх өвчний гаралтыг 5-10 хувь бууруулна.	Улсын төсөв, ОНТ, төсөл хөтөлбөр
					АЗДТГ, МЭГ, МЭҮНэгж

мал сүргийг ялган тэмдэглэх тогтолцоог хөгжүүлэх	Мал сүргийн ялган тэмдэглэх бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэн, цахим бүтгэлээр дамжуулан хяналтын тогтолцоог бэхжүүлэх, жил бүр холбогдох мэдээллийг баяжуулж хэвших	Цахим системийн хэрэгжилтээр	Цахим бүртгэлийн систем бүрэн хэрэгжиж, мэдээлэлийн бүртгэл шинэчлэгдэнэ	Улсын төсөв, ОНТ, төсөл хөтөлбөр	АЗДТГ, МЭГ, МЭҮНэгж
	Монгол улсын малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн өндөр идэвхтэй, чанартай эм бэлдмэлээр ханган малын эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлсэн байх	Эмийн зохистой хэрэглээний төлөвшилтийг хангах журам зааврыг мөрдлөг болгож хэвшсэн байна	Хэрэглээнд байгаа эмийн нэр төрөл, чанар сайжирна.	ОНТ, төсөл хөтөлбөр, Аж ахуй нэгж	МЭГ, СЗДТГ, МЭҮНэгж
	Орон нутгийн мал аж ахуйн мэргэжилтнүүдийнг чавадхижуулж боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх	Мал аж ахуйн мэргэжилтний хангамжийн хувь, мал үржүүлэг технологийн үйлчилгээний нэгж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн тоо, малын эмчийн тоогоор	Сумдын мэргэжилтний хангамж нэмэгдэх, сум бүр мал үржүүлэг технологийн үйлчилгээний нэгжтэй болох, Нэг малын эмчид ноогдох малын тоо 55-65,0 мянга болсон байна	ОНТ, төсөл хөтөлбөр, Аж ахуй нэгж	АЗДТГ, ХХААГ, МЭГ, СЗДТГ

Зорилт 5: Эрчимжсэн аж ахуйг орон нутгийн онцлогт тохируулан хөгжүүлэх

Эрчимжсэн аж ахуйг орон нутгийн онцлогт тохируулан хөгжүүлэх	Бүтээмж өндөртэй мал сүрэг болон, өндөр ашиг шимт нэг төрлийн амьтан дагнан үржүүлж буй, эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлж буй иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг зах зээлтэй холбох төсөл хөтөлбөрт хамруулан дэмжих	Хагас суурин аж ахуй, мал бордох аж ахуйг хөгжүүлсэн тоо. Өндөр ашиг шимт малын тоо.	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо нэмэгдэж бүтээгдэхүүн үйлдвэрлэл, орлого нэмэгдэнэ.	ОНТ, төсөл хөтөлбөр, Аж ахуй нэгж, малчид	АЗДТГ, ХХААГ, СЗДТГ
5	Хүн ам олноор суурьсан сумдын мах, сүү, сүүн бүтээгдэхүүн,	Хүн ам олноор төвлөрсөн суурин газрыг түшиглэн	Хүн амын хүнсний хамгамж дээшилж, орон нутагаа	ОНТ, төсөл хөтөлбөр, Аж	АЗДТГ, ХХААГ, СЗДТГ

	<p>өндөгний хэрэглээний зохих хувийг эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх замаар шийдвэрлэх</p>	<p>туслах аж ахуй хагжүүлэх, иргэн аж ахуй нэгжийн санаачлагыг дэмжих</p>	<p>үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэнэ</p>	<p>ахуй нэгж, малчид</p>	
<p>Тэжээлийн ургамалын тариалалтыг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх</p>	<p>Тэжээлийн ургамалын тариалалт нэмэгдсэн байна</p>	<p>Тэжээлийн ургамалын тариалалт нэмэгдсэнээр орон нутгаас тэжээл бэлтгэж эрчимжсэн аж ахуй хөгжих боломж нэмэгдэнэ</p>	<p>Улсын төсөв, ОНТ, төсөл хөтөлбөр, Аж ахуй нэгж, малчид</p>	<p>АЗДТГ, ХХААГ, СЗДТГ</p>	
<p>Шинжлэх ухаан, биотехнологийн дэмшилтэд аргыг нэвтрүүлэх, цар хүрээг өргөжүүлэн хөгжүүлэх</p>	<p>Мал сүрэгт өндөр ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх, өсвөр хээлтүүлэгч бойжуулах зэрэг замаар хээлтүүлэгч малын чанарыг сайржуулах, шилмэл хээлтүүлэгчийг үржилд бүрэн ашиглах</p>	<p>Нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх</p>	<p>Улсын төсөв, ОНТ, төсөл хөтөлбөр, Аж ахуй нэгж, малчид</p>	<p>АЗДТГ, ХХААГ, СЗДТГ</p>	